

**“ХЯТАД ХЯРД ГАРАВ, ХЯРСЫН СҮҮЛ ЗАЛАА БОЛОВ”
ГЭДЭГ ТҮҮХЭН ЛОРЖУУ ҮГИЙН ТАЙЛАЛ**

Г.Намжил

Агуулгын товч: “Хятад хярд гарав, хярсын сүүл залаа болов” гэдэг түүхэн лоржуу үг¹ нь Юань улсын Тогоонтөмөр ухаант хаан Мин улсын цэрэгт шахагдан Дайт хотоо хаяж дутаан төр гүрнээ алдсан түүхэн домог ярианы утга санааг хураангуйлан зохиогдсон юм. Өгүүлэлд тус лоржуу үгийн үүслийн түүхэн хэрэг явдал, домог яриаг шинжлэн судалж, лоржуу үгийн үүссэн учир холбогдол, арга зам хийгээд уламжлагдлын явц дахь хувирал улирлыг мөрдөн тайлбарлахыг зорьсон байна.

Түлхүүр үг: *хятад, хяр, хярсын сүүл*

“Хятад хярд гарав, хярсын сүүл залаа болов” бол XVII, XVIII зууны үеийн түүхэн сурвалж бичигт илэрсэн зүйр цэцэн үг мөн. Тэр нь монгол ардын зүйр цэцэн үгийн “хос мөрөөр бүтэх бөгөөд хоёр зүйлийг холбон дүрсэлж, зэрэгцүүлж зүйрлэж өгүүлэх” онцлог шинжид нийцсэн байдаг. Гэхдээ ардын домог, домог яриа, аман үлгэрийн гол агуулга санааг хураангуйлан бүтээсэн ардын зүйр цэцэн үгийг бас лоржуу үг хэмээн нэрлэдэг. Шинжлэн бүхий энэхүү зүйр цэцэн үг нь яг сайхан Монголын түүхэн домог ярианы утга санааг хураангуйлан бүтээсэн болохоор бид үүнийг бас лоржуу үг хэмээн нэрлэж буй. Өгүүлэлд тус лоржуу үгийг үүсгэсэн түүхэн хэрэг явдал, домог яриаг шинжлэн судалж, лоржуу үгийн үүссэн учир шалтгаан, арга зам жич уламжлагдлын явц дахь хувирал улирлыг мөрдөн тайлбарлахыг зорьжээ.

Нэг

“Хятад хярд гарав, хярсын сүүл залаа болов” гэдэг эртний лоржуу үгийг зохиогчийн нэргүй “Хаадын үндсэн хураангуй алтан товч”, Лувсанданзаны “Алтан товч” (бүх нэр нь Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан алтан товч хэмээх оршив), Дов тайжийн “Их шар тууж” (бүх нэр нь Эртний монголын хаадын үндэсний их шар тууж оршив) ба халхын Жамба засгийн “Асрагч нэртний түүх” зэрэг XVII, XVIII зууны үеийн монгол түүх, уран зохиолын сурвалж бичгүүдэд тэмдэглэгдэн оржээ. Гэхдээ энэхүү лоржуу үгэн дэх “хярд” (хир-а-ду) гэдгийг “Хаадын үндсэн хураангуй алтан товч”-ийн зарим бар хэвлэлд “хярд” (хираду) гэх адил бус хоёр янзаар бичив. Үүнд “хириду” гэдэг нь хэлэлгээнгүй “хир-а ду” гэдгийн ташаа бичлэг болно. “Хярс” гэдэг үгийг “Их шар тууж”-ийн зарим бар хэвлэлд “хирса”, “хирс-а” хэмээн хоёр янзаар бичиж буй.

¹ Үлгэрт үг. www.mongoltoli.mn Ред.

Энэхүү эртний лоржуу үг нь одоо болтол тусгай системтэй судлагдаагүй боловч эрдэмтэн мэргэд дурдсан сурвалж бичгүүдийг харгуулж тайлбарлахдаа энэ тухай мөн анзаарсан байдаг. Тухайлбал: Б.Баганаас “Хятад хярд гарав” гэдэг өгүүлбэр дэх “хираду гэж хярсг хэлж байна. Хярс гэж шон гур тавьж заагласан тэр заагийг эртний үед хярс гэдэг, энд Цагаан хэрэмийг зааж хэлжээ” гэжээ. Дээрх эрдэмтний үзэлтийг тус лоржуу үгийн үүслийг тайлбарласан түүхэн хэрэг явдал ба домог яриатай харьцуулж үзвэл “Хятад хярд гарав” гэдэг нь “Хятад” болон “Монгол”-ын хоорондох дайнд хятад цэрэг нь ялагдан урт Цагаан хэрэм дээр гарав гэдэг утгатай гэж тайлбарласан байна. Тус эрдэмтнээс “хираду” гэдгийг “хир-а-ду” хэмээн ойлгосонгүй, харин “хярс” гэх ганц үг хэмээн үзсэн нь сонирхолтой.

Монгол сурвалж бичгийн алдарт эрдэмтэн Чойжоос “Хярд хэмээсэн нь уулын хярыг хэлсэн буюу. Энэ хятад хүнийг доромжлон хэлсэн үг болмуй. Монголын ноёрхогчид Дайдуг алдсаны дараа хятад хүнийг доромшаан, боол байсан хятадууд өндөр дээр гарав, болхи муу хярсын сүүлээр залаа (малгайн залаа) болгосон мэт хэмээсэн хошин зүйр үг буюу” гэжээ. Зохиогч миний үзэхээр Чойжийн энэхүү тайлбар нь тун зөв оновчтой юм. Түүний тайлбарыг энгийн бодитой хэлбэл, тус лоржуу үгийн өмнөх өгүүлбэр нь боол хятад ноён болсон гэдгийг илтгэн, сүүлчийн нэг өгүүлбэр нь үүнийг хошигнон доромжилсон утгаар хэрэглэгдэж байдаг. Булагийн тайлбар нь: “хир-а хэмээгч уулын хяр буюу. Энэ бол монголчууд Мингийн цэргийг хошигнож доромжилсон үг буюу. Ойлгомжтой шиг хэлбэл, хятадын цэрэг өндөрт гарч хярсын сүүл залаа болов хэмээх үг болно” гэжээ. Жү Фэн, Жя Жин янь хоёр эрдэмтэн багшийн “Хаадын үндсэн хураангуй алтан товч”-ийн хятад орчуулгад тус үгийг 汉军出了野狐岭, 狐尾变成帽缨子 гэж орчуулжээ. Тэд тус лоржуу үгэн дэх “хир-а” гэдэг үгийг умард орны түүхэн газрын нэр Е Ху лин даваа [野狐岭] хэмээн ойлгож орчуулсан байна.

Е Ху лин давааг хятадууд түүхэн дээр нэгэн үе 扼胡岭 (“умарчуудыг боомилох даваа” гэх утгатай) хэмээн нэрлэж байжээ. Одоогийн Хэбэй мужийн Вань Чюань сянийн баруун хойд талд байгаа урт даваа болно. Энэ бол түүхэн дээрх хятад, монгол орны хоорондох зам харилцаанд зайлшгүй давах даваа боомт болох юм. Түүхэн дээр умардын үндэстнүүдийн морьт цэрэг удаа дараалан Е Ху лин давааг давж дотор орныг довтолдог байжээ. Дундад орны вант төрийнхөн ч мөн тус давааг давж умардын үндэстнүүдийг довтлон дарангуйлдаг байсан юм. Тус давааг хятад хэлэнд “умарчуудыг боомилох даваа” гэх утгатай үгээр нэрлэж байсан нь ч үүнийг харуулж байна. Түүхэн тэмдэглэлийг үндэслэвэл, Алтан улс болон Монгол улсын хоорондох том дайн энд явагдаж өнгөрөв. Хун Ү-ийн гуравдугаар он (1370 он)-д Мин улсын их жанжин Ли Вэнь жүн бээр Е Ху лин давааг давж Юань улсын цэргийг ихээр үлдэн довтолж алж хядаж билээ. Мин улсын Жү Ди Юнлэ хаан монголчуудыг таван удаа довтолоход бүр Е Ху лин даваагаар өнгөрсөн юм.

Монголчууд Е Ху лин давааг “Үнэгэн даваа” гэдэг. “Монголын нууц товчоо”-ны 247 дугаар зүйлд “Үнэгэн даваа” гэдэг үгийн хажуугийн орчуулга нь 野狐岭 гэжээ. Монгол, хятад хэлний “Үнэгэн даваа” болон “Е Ху лин” нь үнэндээ адил утгатай үг мөн. “Монголын нууц товчоо”-нд бичсэн нь: “Түүний хойно, Чингис хаан хонин жил (1211 он) хятад иргэнд морилав. Фү жөү [抚州] одоогийн Хэбэй мужийн Зан бэй шянь)-ийг авч, Үнэгэн даваагаар давж, Шюань Дэ фү [宣德府] одоогийн Хэбэй мужийн Шюань Хуа сянь)-ийг авч Зэв, Хуйханагбаатар хоёрыг манлай илгээв” гэжээ. Дээрхийг бусад түүх сурвалж дахь тэмдэглэлийг харгуулж үзвэл, 1211 онд Чингис хаан биеэр их цэрэг дайчлан Алтан улсыг довтолохдоо Алтан улсын цэрэгтэй Үнэгэн даваанд үхэж сэхэхийн дайн хийсэн юм. Энэ удаагийн дайныг түүхэн дээр “Үнэгэн давааны дайн” гэдэг.

Нэг үгээр хэлбэл, эртний үеийн Үнэгэн даваа бол ар газар болон дотор орны хоорондох зайлшгүй нэвтрэх зам шугам, цэрэг дайны чухал боомт байж, түүхэн дээр энд өмнө умарын

том дайн дажин явагдсан юм. Газрын байцаас үзсэн ч энд бол урт үргэлжилсэн даваа байж, даваан дээрх хамаг өндөр газар нь далайн түвшнээс 1700 метр дээш өргөгдсөн байдаг. Иймээс Жү Фэн авгай нар тус лоржуу үгэн дэх “хир-а”-ыг 野狐岭 хэмээн орчуулсан нь онцгой таамаг бодолтой байсан нь тодорхой.

Хоёр

“Хятад хярд гарав, хярсын сүүл залаа болов” гэдэг лоржуу үг бол Хубилай цэцэн хааны байгуулсан Их Юань улсын сүүлийн хаан Тогоонтөмөр ухаант хааны Мин улсад ялагдан төр гүрнээ алдсан тухай түүхэн хэрэг явдал, домог ярианаас үүсжээ. Тус домог яриа нь “Хадын үндсэн хураангуй алтан товч” зэрэг XVII, XVIII зууны үеийн түүхэн сурвалж бичигт тэмдэглэгдэн оров. Үүнийг одоох хэлэнд хялбарчлан буулган сийрүүлбэл доорх мэт:

Тогоонтөмөр ухаант хааны үед Зүрчид өвгөний Жүхэ нэрт хөвүүнийг төрөхөд гэрээс нь солонго татав. Үүнд Лаган, Яваху хоёр мэргэд мэдэж, хаанд: “Энэ хөвүүн хойшид хаанд муу хортой, өчүүхнээс нь үгүй болгогтун!” гэж сануулжээ. Хаан тэр хоёрын үгийг сонссонгүй. Жүхэ өссөнд хаан зүүн гурван мужийн улсаа даргалуулав. Баруун гурван улсын мужийг Тогтоо, Харзан хоёроор ноёлуулжээ. Жүхэ, Бух ах дүү хоёр Тогтоо, Харзан хоёрыг хаанд ховлон: “Энэ хоёр дарга санг чинь дарж, их сайныг өөртөө эдэл, өчүүхэн мууг нь хаанд авч ирнэм” хэмээн муулав. Хаан Жүхэ, Бух хоёрын үгийг үнэмшиж Тогтоо, Харзан хоёулыг авч ир гэж тэд хоёрыг хоёронтой илгээсэнд, Жүхэ нар хагас замаасаа буцан ирж, тэр хоёр хаантай золгохоор ирэхгүй байна гэж мэдүүлэв. Хаанаас Жүхэ, Бух хоёулыг алба сан хураахаар илгээсэнд гурван жил буцаж ирсэнгүй. Хаан: “Жүхэгийн хөл асар хүнд болов” хэмээн сэжиглэж, тэд хоёулыг ирвэл хотын хаалгыг битгий нээж өг гэж хаалгачинд зарлиг болов.

Хаан нэгэн шөнө хот дайсанд давхар давхар бүслэгдэж, дутаан гарах зав чөлөө эрсээр хотын баруун хойд өнцгөөс нэг нүх олж, хаан ороо хаяж, хамаг улсаа орхин тэр нүхээр зугатан гарав гэж зүүдэлжээ. Хаан: “Энэ зүүд минь сайн буюу, муу буюу?” хэмээн Хятадын Гэгээн цэцнээс асуусанд “Хаан ороо алдах ёр буюу!” хэмээн тайлжээ. Хаан зүүдний бэлгээр хотын баруун хойд хүрч үзвэл үнэхээр тийм нүх байсныг мэдэж, улс маань мөхөх буюу хэмээн эмээв.

Түүний хойно, Жүхэ, Бух хоёр түмэн хасагт алба сан түгээж ирэв хэмээн гурван мянган хасагт нь хуяг цэргээ нуун хүрч ирэв. Хаалгачин хааны зарлигаар хотын хаалгаа нээж өгсөнгүй. Жүхэ нар хаалгачинд эд эрдэнэ түлхэн хотод орж ирэв. Жүхэ, Бух хасгаасаа цэргээ гаргаж ирээд хааны алтан ордыг бүслэхийг завдтал хаан мэдэж, дөчин түмэн монголоос арван нэгэн түмийг нь авч урьдын үзсэн тэр нүхээр хатдын хөвүүдээ дагуулан дутаан гарав. Хааныг тэр гарахад Хавт Хасарын хойчис Дух баатрын хүү Тухлах баатар хөвүүнээ Хач хүлгийг гаргаад жаран хиртнээ удирдаж ирээд “Нэрээ хугарахаар ясаа хугар гэдэг билээ!” хэмээн хятадын нэхсэн цэргүүдийг угтан алалдаж үхэв гэдэг.

Хаан Молтогчин Сүвээр гарч Барс хотыг барьж суув. Хятад Хярс хотыг барьж суув. Тэндээс Ухаант хааны хөвүүн Билэгт задалж их шуурган бороо оруулж, хятадын эр агтыг бутартал үхүүлэв гэх. Түүнээс үлсэн хятадын цэрэг буцаж ирэхдээ монголын цэрэг хойноос нь нэхэж Цагаан хэрэм хүртэл цавчив гэх. Тэндээс тархаж дутаасан цэргүүд нь зэвээ түлж зуухан дээр хэвтэж үхэв гэх. “Хятад хярд гарав, хярсын сүүл залаа болов” гэгч энэ.

Дээрх бол Тогоонтөмөр ухаант хаан Мин улсын цэргийн бүслэлт довтолтоос зайлж, их нийслэл Дайду хотоо хаяж дутаасан ба Хятад, Монголын цэрэг дайралдсан түүхэн хэрэг явдлаар сэдэвлэж зохиогдсон домог яриа болно. Домог яриан дахь хүн, үйл явдал зэрэг нь түүхийн бодит хүн, хэрэг явдал лугаа тун их зөрөөтэй, тэдгээр хүн ба хэрэг явдлын олонх нь

сүүлчийн хүмүүсийн зохион бүтээсэн уран санааны дүр бүтээгдэхүүн мөн. Ялангуяа “тэндээс Ухаант хааны хөвүүн Билэгт задалж их шуурга бороо оруулж, хятадын эр агтыг бутаргал үхүүлэв” гэх мэтийн хэллэг бол зөвхөн монгол ноёрхогчдын төр гүрнийг нь булаасан хятадыг занаж, хорслоо гаргасан төдий юм.

Түүхэн домог яриа бол түүхэн дэх бодит хэрэг явдлын урлаг тусгал мөн. Иймээс бүхэлд нь авч үзвэл дээрх домог яриа нь нэг талаар Юань улсын сүүлч үеийн хаан ордны дотоодын зөрчил тэмцэл, эзэн хааны мэргэн цэцэн дутмагдсан байдлыг дамаар илтгэн үзүүлжээ. Нөгөө талаар голдуу Дайду хот Мин улсын цэрэгт бүслэгдэн аюул түгшүүртэй болоход Тогоонтөмөр хаанаас хатан татвар, үр хүүхэд, сайд түшмэд ба хэсэг цэрэг ардаа дагуулан хотоос дугаан гарч Хятадын төрд гүрнээ алдсан түүхэн хэрэг явдлыг урлагийн талаар тусгажээ. Мөн ч дээрх түүхэн хэргээс сэдэвлэсэн домог ярианаас “хятад хярд гарав, хярсын сүүл залаа болов” гэх лоржуу үг үүсэн дэлгэрчээ. Тэгвэл тус лоржуу үг нь ямар утга санааг илтгэсэн гэдгийг ойлгоё гэвэл хамаг түрүүнд тус лоржуу үгэн дэх “хир-а” гэдэг үгийг ойлгох чухалтай юм.

Лоржуу үгэн дэх “хир-а” гэдэг үгийг эрдэмтэд “уул хяр”-ын “хяр” хэмээн тайлбарлаж, Юань улсыг мөхөөсөн хятадын өндөр байр суурийн бэлгэдэл хэмээн үзэж, “хятад хярд гарав” гэдэг нь боол байсан “хятад” ноёлогч болсон гэдгийн далд утга бүхий үг хэмээн үздэг. Миний үзэхээр эндэх “хир-а” нь дээрх утгатайгаар барахгүй бас тусгай газрын нэр буюу хот бэхлэлтийн нэрийн бэлгэдэл ч байж болно. Энэ тухай Жү фэн, Жя Жин янь хоёр авгай бээр тус лоржуу үгэн дэх “хир-а”-г Е Ху лин хэмээн орчуулан тайлбарласан нь учиртай юм. Дээрх домог ярианд хятадын байгуулсан “Хярс хот” гэдэг нь Мин улсаас Үнэгэн даваанд байгуулсан хот бэхлэлтийг зааж буй.

Бодитоор хэлбэл, Мин улсын Хун Ү-ийн гуравдугаар он (1370 он)-д Жү Юань зан бээр их жанжин Ли Вэнь жүн (1339-1384)-д арав гаруй түмэн цэрэг өгч Юань улсын цэргийг довглуулжээ. Ли Вэнь жүнгийн цэрэг Үнэгэн давааг давж Монголын хааны дагуулсан цэрэгтэй тулалдан ялж, хааны хүү Майдарбал жич хатан татвар, их түшмэл хэдэн зуун хүнийг олзлон хааны хасбуу тамгыг гардан авч, монгол цэргийг мохтол ялж цэргээ хураан буцаав. Ли Вэнь жүн нар энэ удаа мөн Монголын хойшдын довтлолтыг сэргийлэхийн төлөө Үнэгэн даваанд хот бэхлэлт цогцлон сахиулсан юм. Энэ хот бэхлэлт бол даруй дээрх домог яриа гардаг Хярс хот бололтой.

Хярс бол үнэгний нам мөн. “Хорин нэгт тайлбар толь”-д “хярс - үнэгэнд адилхан, өнгө цагаавтархан” гэжээ. Иймээс Үнэгэн даваанд байгуулсан хот бэхлэлтийг бас “Хярс хот” хэмээн нэрлэж болох юм. Хярс хот нь бас өндөр газар байгуулагдсан болохоор лоржуу үгэнд “хир-а” хэмээн төлөөлөн нэрлэсэн байж болно.

Дээр дурдсанчлан, түүхэн дээр Үнэгэн даваа бол Монгол, Хятад орны хоорондох цэрэг дайны чухал боомт байж, умардын үндэстнүүд ер нь тус боомтыг амархан эзэмддэг байжээ. Гэтэл Мин улсын эхний үед Мин улс монголыг ялж Үнэгэн давааг эзэмдэн тэнд хот бэхлэлт байгуулан сахисан байжээ. Үүгээр бэлгэ тэмдэг энэ үеийн хятадын байр суурь нь урьд өмнө гараагүй дээшилснийг харуулж, мөртөө боолоосоо нэг л дээр хаан эзэн болсон гэдгийг бэлгэджээ. Иймээс тус лоржуу үгэн дэх “хятад хярд гарав” гэдэг өгүүлбэрийг нь тухайн үеийг Хятадын байр суурийн урьд өмнө гараагүй дээшилснийг илтгэжээ. Мөн ч Монголын ноёрхогчид “хятад хярд гарсан”-д дургүйцэн, дотроосоо мэдрэхгүй байжээ. Иймээс тэд бас “хярсын сүүл залаа болов” гэх өгүүлбэрийг нэмж, хятадыг хошигнон доромжилж, хорслоо гаргах болжээ.

Гурав

“Хятад хярд гарав, хярсын сүүл залаа болов” гэх лоржуу үг нь хэдийгээр XVII зууны үеийн “Хаадын үндсэн хураангуй алтан товч” зэрэг түүхэн сурвалж бичигт тэмдэглэгдэн орсон боловч, тэр нь үнэндээ Юань улсын сүүлч, Умард Юань улсын эхний үеийн Монгол, Хятадын түүхэн хэрэг явдал ба үлгэр домгоос урган гарсан юм. Тэр нь ард олны дунд зохиогдож ам чихээр дамжин уламжлагдсаар эцэстээ түүхэн бичиг сурвалжид тэмдэглэгдэн бидний үед хүрч иржээ. Гэхдээ тэр нь хэрэв ардын дунд амаар зохиогдон уламжлагдсан байвал заавал бичиг сурвалжийн тэмдэглэлээс гадна бас ардын аман ярианд үлдэгдэн хоцорсон байх ёстой.

Зохиогчоос иймэрхүү таамаг бодлоо өвөрлөн ном бичиг урвуулан эрэн сорьж үзвэл, дээр зууны гучаад оны үед Бельгийн монголч эрдэмтэн А.Мостаэртын эмхэтгэн цуглуулсан “Ордос ардын аман зохиол” гэдэг номд тэмдэглэсэн мэргэ төлгийн үгийн дотор дээрх лоржуу үгийн нэгэн хувилбар байгааг олж харжээ. Энэхүү мэргэ төлгийн үгийг сийрүүлбэл доорх мэт:

Хасагийн мөр ханан эрээн болоход
Хонин хоргол үгүй болоход
Хятадын хүү ноён суухад
Хярсын сүүл залаа болоход
Шаазангийн хагархай тал дүүрэхэд
Олгой гэрт суухад
Гурван толгойтой ат маллах цагт
Чингис морилж ирэх

Энд илэрсэн “хятадын хүү ноён суухад, хярсын сүүл залаа болоход” гэх нь шинжлэн бүхий “хятад хярд гарав, хярсын сүүл залаа болов” гэдгийн нэгэн хувилбар болох нь гарцаагүй. Энэ хоёрыг харьцуулж үзвэл, ардын аман яриан дахь лоржуу үг нь бичгийн лоржуу үгийн “хятад хярд гарав”-ыг “хятадын хүү ноён суухад” гэх үгээр сольж, нэн хялбарчлан ойлгоход дөхөм болгосон юм. “Хятад хярд гарав” гэдэг үгийг аван ойлгоход бэрхтэй, харин “хятадын хүү ноён суув” хэмээн тус лоржуу үгийн үүсэл гарлын түүхт хэрэг явдал буюу домог яриаг гадарлахгүй хүн ч гэсэн утга санааг нь ойлгож болно. Энэ бол тус лоржуу үгийн ардын дунд ам чихээр уламжлагдах явцад илэрсэн хувиралт болно.

Байцаалтыг үндэслэвэл, тус лоржуу үгийн хувилбар нь Ордос ардын дотор яригдаж байснаар барахгүй, бусад орны ардын аман ярианд ч дэлгэрч байжээ. Тухайлбал, Бүрэнтөгсийн ойрд найруулсан “Монгол хэлцийн далай”-д “хятад хярд гарч, хярсын сүүл залаа болох”, “хятад хярд гарч, хярсын сүүл толгойд гарах” гэх хоёр лоржуу үгийг тэмдэглэжээ. Гэхдээ өмнөх нь бараг “Хаадын үндсэн хураангуй алтан товч” зэрэг сурвалж бичгээс хуулсан бололтой. Хойнох нь дурдсан “Монгол хэлцийн далай” гэдэг толиос өмнөх Дундад улсад хэвлэгдсэн зүйр цэцэн үгийн чуулганууд ба монгол хэлц, хэвшмэл үгийн толь бичгүүдэд ер нь харагдсангүй. Толийн эмхэтгэн найруулагчаас үүнийг хаанаас олсон гэдэг нь тодорхой биш байна. Энд тэмдэглэгдсэн хоёр лоржуу үгийг хооронд нь харьцуулж үзвэл, өмнөхийн “хярсын сүүл залаа болох” гэдгийг хойнох “хярсын сүүл толгойд гарах”-аар сольж нэн ойлгомжтой болгожээ.

Дараалбал, Монгол улсын Г.Ринченсамбуу, Ж.Дашдоржийн эмхэтгэн найруулсан “Монгол ардын зүйр цэцэн үг” гэдэг эмхэтгэлд, “хятад хярд гарч, хэрмийн сүүл толгойд гарах” гэдэг аман хувилбар тэмдэглэгджээ.

Зохиогчийн үзэхээр говийн арын монголчуудад дэлгэрсэн “хятад хярд гарч, хэрмийн сүүл толгойд гарах” гэдэг лоржуу үг бол сурвалж бичигт “хятад хярд гарав, хярсын сүүл залаа болов” гэдэг лоржуу үгийн бас нэгэн аман хувилбар мөн. Гэхдээ сурвалж бичиг дэх лоржуу

үг нь ардын аман ярианд дэлгэрэн уламжлагдах явцад “хярс” нь “хэрэм”-ээр, “залаа болов” нь “толгойд гарах”-аар тус тус солигдсон байна.

Хоёрдох солигдлын учир шалтгааныг ойлгоход хялбар тул энд задлахгүй. “Хярс” нь яагаад “хэрэм”-ээр солигдсон тухай зохиогчоос доорх мэт задалъя.

Дээр дурдсанчлан хярс бол үнэгний нам, амьдралын зан чанар, онцлог шинж нь үнэгтэй адил, өнгө зүсэм нь үнэгээс бага зөрөөтэй. Ерөнхийд нь үзвэл, хярс бол үнэгтэй адилаар, монголчуудын аман ярианд энэ хоёрыг төдий ялган салгахгүй, бараг бүр үнэг гэж нэрлэдэг байна. Иймээс хярс гэдэг амьтны нэр бичиг зохиолд хааяа гардаг боловч, ардын аман ярианд маш цөөн сонсогддог. Дундад улс ба Монгол улсад түүвэрлэгдэн хэвлэгдсэн монгол ардын зүйр цэцэн үгийн түүвэр чуулгануудыг шүүж үзвэл “хярс” гэдэг үг бараг гардаггүй, мөн ч хяrsaар сэдэвлэсэн зүйр цэцэн үг тун цөөн, харин үнэг гэдэг үг маш олон байдаг бөгөөд үнэгээр сэдэвлэсэн зүйр цэцэн үг маш олон гардаг. Мөн ч үнэгээр сэдэвлэсэн ардын аман үлгэр тун олон, харин хяrsaар сэдэвлэсэн аман үлгэр бараг байдаггүй. Үүнээс үзвэл, монголчуудын аман ярианд үнэг хийгээд хярсг төдий ялгахгүй, бүр үнэг хэмээн нэрлэж байжээ.

Мин улсын Вань лигийн гучин наймдугаар он (1610 он)-д барлан сийлсэн “Лү лүн сай люай” хэмээх бичгийн арван ес, хорьдугаар боть, орчуулгын бүлэгт 狐, 曰忽捏干, 曰气儿撒, 沙狐也 гэж тэмдэглэжээ. Дээрхийг монголоор орчуулбал: “Монголчууд үнэгийг бас хярс хэмээмүй, хярсг хятадаар ша ху (沙狐) хэмээмүй” гэдэг утга буй. Үүгээр үзсэн ч эртнээс аваад монголчууд хярсг мөн үнэг хэмээн үзэн нэрлэж байжээ. Иймээс хярс гэдэг үг монголын зарим нутгийн аман ярианд аажимдаа төдий хэрэглэгдэхээ больж, эртний лоржуу үгийн “хярс”-ыг “хэрэм” гэх үгээр солигдоход хүргүүлсэн юм.

Дээрхийг хураангуйлбал, “Хятад хярд гарав, хярсын сүүл залаа болов” гэдэг үг нь Юань улсын сүүлч Умард Юань улсын эхний үеийн Монгол, Хятадын хоорондох дайн байлдаан, Монголын төр гүрэн Хятадад алдагдсан түүхэн хэрэг явдал, домог ярианаас үүсжээ. Лоржуу үгэнд, Монголын ноёрхогчид ба хэсэг бүлэг хүмүүс төр гүрнийг нь булаасан хятадад дургүйцэн, тус лоржуу үгийг зохион “боол хятад дээш дэвшиж ноёлогч болсон нь болхи муухай хярсын сүүлээр малгайн залаа болгосонтой адил” хэмээн дооршоон хошигносон санаагаа илтгэж, сэтгэл зүрхний хорслоо гаргажээ. Тус лоржуу үг нь XIV зууны сүүлчээр Юань улсын ноёрхол нурах үеэр ардын аман ярианд зохиогдон дэлгэрч, XVII зууны үеийн бичиг зохиолд тэмдэглэгдэн оржээ. Үүний дагуу, ард түмний аман ярианд уламжлагдан дэлгэрэх явцад үг өгүүлбэр нь өөрчлөгдөн аван ойлгож, авч хэрэглэхэд нэн хялбар дөхөм болгосон байна.

Resume

Proverb, which condenses the folk wisdom in the age long historical time, usually denominated as “Lorzoo ug” in Mongolian. “Hitad Hirad garab, hirsya-yin suul zalaga bolob”, a widespread proverb which origin can be traced back to the last emperor of Yuan dynasty, Togontemur Uhaant Khan, is meticulously studied in this paper. The historical event of the defeat of Togontemur and the escape of this last emperor to his native land, comprises the background of this proverb. This paper related the origin, mutation and transmission route of this proverb.

Номзүй

- Асрагч нэртийн түүх.** Б.Багана харгуулж тайлбарлав. Бээжин, Үндэстний хэвлэлийн хороо. 1984.
- Монголын нууц товчоо** (гутгаар дэвтэр). Баяр буулгав. Хөххот, Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо. 1980.
- Хаадын үндэс хураангуй Алтан товч.** Булаг харгуулж тайлбарлав. Хөххот, Өвөр Монголын Сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо. 1989.
- Монгол хэлцийн далай.** Бүрэнтөгс найруулав. Хөххот, Өвөр Монголын Сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо. 2001.
- Ардын аман зохиолын онол.** Мандахын зохиолын чуулган. Хөххот, Өвөр Монголын хэвлэлийн бүлэглэл, Өвөр Монголын Соёлын хэвлэлийн хороо. 2014.
- Ордосын аман зохиол.** А.Мостаэрт цуглуулж эмхтгэж, Соном буулгав. Хөххот, Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо. 2010.
- Монгол ардын зүйр цэцэн үг.** Г.Ринченсамбуу, З.Дашдорж эмхэтгэн найруулав. Түнляо, Өвөр Монголын хэвлэлийн бүлэглэл, Өвөр Монголын Багачууд хүүхдийн хэвлэлийн хороо. 2014.
- Эртний Монголын хаадын үндэсний их Шар тууж оршив.** Өлзийт харгуулж тайлбарлав. Бээжин, Үндэстний хэвлэлийн хороо. 1983.
- Хорин нэгт тайлбар толь.** Хөххот, Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо. 1977.
- Хаадын үндэс хураангуй Алтан товч.** Ш.Чоймаагийн эх бичиг судалсан гэрэл зургийн хэвлэл. Уб., 2002.
- Алтан товч.** Чойж тулган харьцуулж тайлбарлав. Хөххот, Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо. 1983.
- 朱凤、贾敬颜译. 汉译蒙古黄金史纲, 呼和浩特, 内蒙古人民出版社, 1985 年
- 贾敬颜、朱凤合辑. 蒙古语译语、女真译语汇编, 呼和浩特, 天津古籍出版社, 1990 年

Монгол бичгээс хөрвүүлсэн: Н.Ичинноров